



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цэцэн-Уул сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2025/065/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улиастай хот 2025 он</p>	<p>Төрийн аудитын газрын тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа Утас: 99993365 Цахим хаяг: <a href="mailto:Bat-undraaD@audit.gov.mn">Bat-undraaD@audit.gov.mn</a></p> <p>Ахлах аудитор: Х.Болдбаатар Утас: 99105506 Цахим хаяг: <a href="mailto:BoldbaatarKh@audit.gov.mn">BoldbaatarKh@audit.gov.mn</a></p> <p>Аудитор: Г.Баасанжаргал Утас: 99032514 Цахим хаяг: <a href="mailto:BaasanjargalG@audit.gov.mn">BaasanjargalG@audit.gov.mn</a></p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	2
.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	14
3.5.1 Төсвийн төлөвлөлт .....	14
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	14
3.5.3 Нэмэлт төсөв.....	15
3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн.....	15
3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар.....	15
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	15
4.1 Ерөнхий зүйл.....	15
4.2 Материаллаг байдал .....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд .....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	17
4.5.1 Завсрын аудитын талаар.....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	17
5.1 Төлбөрийн акт.....	18
5.2 Албан шаардлага.....	18
5.3 Зөвлөмж .....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	19

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

81090 Улиастай, Завхан аймаг  
Утас/Факс: 7046-36-12  
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2025.02.22 № 257

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ЦЭЦЭН-УУЛ СУМЫН ЗАСАГ  
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Ц.БАЯНМӨНХ-Д

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цэцэн-Уул сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цэцэн-Уул сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Цэцэн-Уул сумын Засаг даргын Тамгын газар нь сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн 39.8 сая төгрөгийн гэрэлтүүлгийг данс бүртгэлд тусгаагүй, сумын аюулгүйн нөөцийн бэлтгэхээр 18.8 сая төгрөгөөр худалдан авсан өвсийг бараа материал дансаар дамжуулалгүй шууд зардлаар тайлагнасан зөрчлийг аудитын явцад залруулсан байна.

### Аудитын гол асуудал

Цэцэн-Уул сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар газрыг үнэлж, данс бүртгэлд бүртгэх зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

### Бусад асуудлын хэсэг

Цэцэн-Уул сумын Засаг даргын Тамгын газар нь тайлант онд 304.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг, 2.7 сая төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор бүртгэн холбогдох дансанд тусгасан байна.

D:\disk\Албан бичиг\Дүгнэлт

817502447

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ****2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

/мян.төг/			
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>36,446.10</b>	<b>77,793.83</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>421.69</b>	<b>68.06</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	421.69	68.06
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>36,024.42</b>	<b>77,725.77</b>
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>32,824.42</b>	<b>74,525.77</b>
35410	Бичиг хэргийн материал	2,641.38	3,158.28
35420	Аж ахуйн материал	25,266.59	29,483.04
35430	Сэлбэг хэрэгсэл	3,779.45	3,779.45
35450	Барилгын засварын материал	627.00	9,945.00
35470	Бусад хангамжийн материал	510.00	28,160.00
35600	Мал амьтад	3,200.00	3,200.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>621,216.94</b>	<b>908,888.00</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>621,216.94</b>	<b>908,888.00</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>619,751.06</b>	<b>907,594.00</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	618,123.68	660,524.98
39202	Хуримтлагдсан элэгдэл	(175,567.88)	(200,804.95)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	156,584.80	382,683.31
39204	Хуримтлагдсан элэгдэл	(121,032.09)	(133,424.10)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	118,179.60	127,754.60
39206	Хуримтлагдсан элэгдэл	(56,086.62)	(76,320.99)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	25,147.78	44,547.78
39208	Хуримтлагдсан элэгдэл	(22,436.79)	(24,553.76)
39214	Бусад үндсэн хөрөнгө	156,100.41	217,782.91
39215	Хуримтлагдсан элэгдэл	(81,351.78)	(92,685.73)
39217	Ном	2,089.95	2,089.95
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>1,465.88</b>	<b>1,294.00</b>
39301	Програм хангамж	2,802.00	2,802.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,630.13)	(2,802.00)

39303	Бусад биет бус хөрөнгө	1,294.00	1,294.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>657,663.04</b>	<b>986,681.82</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>657,663.04</b>	<b>986,681.82</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>657,663.04</b>	<b>986,681.82</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	331,501.29	331,501.29
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	331,501.29	331,501.29
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>106,630.18</b>	<b>435,648.96</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	102,566.14	106,630.18
51220	Тайлант үеийн үр дүн	4,064.03	329,018.78
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	-	-
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	219,531.57	219,531.57
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>657,663.04</b>	<b>986,681.82</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	/мян.төг/	
		ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>577,518,071.60</b>	<b>1,586,734.28</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>43,818.92</b>	<b>372,157.46</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>43,818.92</b>	<b>372,157.46</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	-	<b>39,858.50</b>
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	39,858.50
120009	Бусад орлого	-	28,300.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	43,042.42	301,297.51
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	776.50	2,701.45
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>533,699.15</b>	<b>1,214,576.82</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>61,688.05</b>	<b>417,953.62</b>
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	61,688.05	417,953.62
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>472,011.10</b>	<b>796,623.20</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	472,011.10	796,623.20
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>573,454.04</b>	<b>1,257,715.49</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>573,454.04</b>	<b>1,257,715.49</b>

<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>550,457.60</b>	<b>956,055.15</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>311,610.10</b>	<b>477,087.92</b>
210101	Үндсэн цалин	227,939.69	332,985.62
210102	Нэмэгдэл	83,225.41	144,102.30
210104	Урамшуулал	445.01	-
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>64,308.05</b>	<b>76,064.03</b>
210201	Тэтгэврийн даатгал	44,834.87	52,170.64
210202	Тэтгэмжийн даатгал	5,115.63	5,907.76
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,858.75	4,797.58
210204	Ажилгүйдлийн даатгал	851.62	2,816.97
210205	Эрүүл мэндийн даатгал	9,647.18	10,371.09
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>27,034.33</b>	<b>36,597.30</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,761.39	2,892.62
210302	Түлш, халаалт	24,272.94	33,704.68
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>21,561.94</b>	<b>24,947.50</b>
210401	Бичиг хэрэг	2,839.60	3,232.75
210402	Тээвэр, шатахуун	16,558.34	19,514.25
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,164.00	1,920.50
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	280.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,947.30</b>	<b>3,306.00</b>
210604	Урсгал засвар	2,947.30	3,306.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>4,754.00</b>	<b>5,365.60</b>
210702	Дотоод албан томилолт	4,754.00	5,365.60
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>70.47</b>	<b>956.93</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	702.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	48.47
210803	Даатгалын үйлчилгээ	-	173.45
210804	Тээврийн хэрэгслийн татвар	48.47	-
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	30.00
210807	Газрын төлбөр	-	3.01

<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>118,171.41</b>	<b>331,729.87</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	61,695.30	259,941.52
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	150.00	303.40
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	56,326.11	71,484.95
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>22,996.44</b>	<b>301,660.34</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>59,864.41</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	28,841.40
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	31,023.01
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>22,996.44</b>	<b>241,795.93</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,669.00	68,451.06
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	20,327.44	173,344.87
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>4,064.03</b>	<b>329,018.78</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>4,064.03</b>	<b>329,018.78</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мян.төг/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>533,817.15</b>	<b>1,214,576.82</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>118.00</b>	<b>-</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>118.00</b>	<b>-</b>
120009	Бусад орлого	118.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>533,699.15</b>	<b>1,214,576.82</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>61,688.05</b>	<b>417,953.62</b>
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	61,688.05	417,953.62
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>472,011.10</b>	<b>796,623.20</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	472,011.10	796,623.20
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>518,449.17</b>	<b>1,196,576.82</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>518,449.17</b>	<b>1,196,576.82</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>495,452.73</b>	<b>894,916.48</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>332,911.19</b>	<b>485,599.73</b>
210101	Үндсэн цалин	241,434.62	299,492.74

210102	Нэмэгдэл	91,031.56	186,107.00
210104	Урамшуулал	445.01	-
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>43,453.80</b>	<b>67,198.60</b>
210201	Тэтгэврийн даатгал	29,548.50	45,695.10
210202	Тэтгэмжийн даатгал	3,476.30	5,375.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,781.10	3,106.60
210204	Ажилгүйдлийн даатгал	695.30	2,269.20
210205	Эрүүл мэндийн даатгал	6,952.60	10,751.80
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>28,234.33</b>	<b>36,297.30</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,761.39	2,651.10
210302	Түлш, халаалт	25,472.94	33,646.20
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>19,918.84</b>	<b>20,366.59</b>
210401	Бичиг хэрэг	2,636.50	3,562.89
210402	Тээвэр, шатахуун	15,118.34	14,833.20
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,164.00	1,970.50
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,024.90</b>	<b>2,007.00</b>
210604	Урсгал засвар	2,024.90	2,007.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>4,512.00</b>	<b>5,365.60</b>
210701	Гадаад албан томилолт	-	-
210702	Дотоод албан томилолт	4,512.00	5,365.60
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>70.47</b>	<b>1,684.21</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	1,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	76.07
210803	Даатгалын үйлчилгээ	-	255.13
210804	Тээврийн хэрэгслийн татвар	48.47	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	150.00
210807	Газрын төлбөр	-	3.01
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>64,327.20</b>	<b>276,397.45</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	64,177.20	276,094.05

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	150.00	303.40
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>22,996.44</b>	<b>301,660.34</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>59,864.41</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	28,841.40
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	31,023.01
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>22,996.44</b>	<b>241,795.93</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,669.00	68,451.06
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	20,327.44	173,344.87
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>15,367.98</b>	<b>18,000.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>15,367.98</b>	<b>18,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>15,367.98</b>	<b>18,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>15,367.98</b>	<b>18,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	15,367.98	18,000.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(15,367.98)</b>	<b>(18,000.00)</b>

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мян.төг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	331,501.29	219,531.57	102,566.14	653,599.01
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	331,501.29	219,531.57	102,566.14	653,599.01
9	Тайлант үеийн үр дүн	-	-	4,064.03	4,064.03
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	331,501.29	219,531.57	106,630.18	657,663.04
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	331,501.29	219,531.57	106,630.18	657,663.04
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	331,501.29	219,531.57	106,630.18	657,663.04
19	Тайлант үеийн үр дүн	-	-	329,018.78	329,018.78
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	331,501.29	219,531.57	435,648.96	986,681.82

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мян.төг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>803,847.40</b>	<b>728,172.14</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>803,847.40</b>	<b>728,172.14</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>743,982.90</b>	<b>668,307.73</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>537,589.80</b>	<b>485,599.73</b>
210101	Үндсэн цалин	379,549.30	299,492.74
210102	Нэмэгдэл	158,040.50	186,107.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>67,198.60</b>	<b>67,198.60</b>
210201	Тэтгэврийн даатгал	45,695.10	45,695.10
210202	Тэтгэмжийн даатгал	5,375.90	5,375.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,106.60	3,106.60
210204	Ажилгүйдлийн даатгал	2,269.20	2,269.20
210205	Эрүүл мэндийн даатгал	10,751.80	10,751.80
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>36,297.30</b>	<b>36,297.30</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,651.10	2,651.10
210302	Түлш, халаалт	33,646.20	33,646.20
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>21,214.20</b>	<b>20,366.59</b>
210401	Бичиг хэрэг	4,360.80	3,562.89
210402	Тээвэр, шатахуун	14,833.20	14,833.20
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,020.20	1,970.50
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,024.90</b>	<b>2,007.00</b>
210604	Урсгал засвар	2,024.90	2,007.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>5,365.60</b>	<b>5,365.60</b>
210702	Дотоод албан томилолт	5,365.60	5,365.60
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,889.70</b>	<b>1,684.21</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,200.00	1,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	560.00	76.07
210803	Даатгалын үйлчилгээ	469.10	255.13

210804	Тээврийн хэрэгслийн татвар	227.70	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	73.80	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	203.40	150.00
210807	Газрын төлбөр	138.30	3.01
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	17.40	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>71,402.80</b>	<b>49,788.70</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	71,099.40	49,485.30
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	303.40	303.40
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>59,864.50</b>	<b>59,864.41</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>59,864.50</b>	<b>59,864.41</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	28,841.40	28,841.40
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	31,023.10	31,023.01
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>803,847.40</b>	<b>728,172.14</b>
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>735,468.80</b>	<b>728,172.14</b>
320001	Орон нутгийн төсвөөс	735,468.80	728,172.14
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>68,378.60</b>	<b>-</b>
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	68,378.60	-
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>
610001	Төсвийн байгууллага	1	1
610002	Төсвөөс гадуур байгууллага	0	0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>20</b>	<b>20</b>
620001	Удирдах ажилтан	8	8
620002	Гүйцэтгэх ажилтан	9	9
620003	Үйлчлэх ажилтан	3	3
620004	Гэрээт ажилтан	0	0
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>20</b>	<b>20</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9	9
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	4	4
650010	Гэрээт ажилтан	0	0
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	7	7

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мян.төг/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>417,953.62</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>417,953.62</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>244,608.75</b>
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>244,608.75</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	244,608.75
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>173,344.87</b>
2133	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>173,344.87</b>
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	173,344.87
I	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>417,953.62</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>417,953.62</b>
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	417,953.62

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Цэцэн-Уул сумын Засаг даргын Тамгын газар нь Монгол улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, Монгол улсын Засгийн газар, аймгийн Засаг дарга, сумын Засаг даргын хөгжлийн төлөвлөгөө, хөтөлбөрүүд, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал түүний Тэргүүлэгчдийн хуралдаанаас гаргасан шийдвэрийг Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд ажиллах төрийн байгууллага, мэргэжилтэн, албан хаагч багийн Засаг дарга нарын ажлыг уялдуулан оновчтой бодлого, зохицуулалтаар хангаж орон нутгийн хөгжлийн төлөө төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллага иргэдэд төрийн үйлчилгээг чанартай шуурхай хүргэж, улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүйгээр иргэддээ үнэнч шударга үйлчлэхэд чиглэгдэнэ.

Тус байгууллага нь “Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, төрийн үйлчилгээг ард иргэдэд хүргэх” гэсэн зорилгын хүрээнд 2024 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 зорилт 101 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Төлөвлөгөөний гүйцэтгэлийг эрх бүхий албан тушаалтнаар дүгнүүлэн 78.5 хувиар үнэлэгдсэн байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Цэцэн-Уул сумын Засаг даргын Тамгын газар нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн албаны тухай, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Шилэн дансны тухай, Хөдөлмөрийн тухай, Татварын ерөнхий хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Төрийн хэмнэлтийн тухай зэрэг хуулиудыг голлон мөрдөхөөс гадна Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам бусад хууль, тогтоомж, журмуудыг мөрдөн ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит болон аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цэцэн-Уул сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Цэцэн-Уул сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2023 оны А/229 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 329,018.8 мянган төгрөгөөр буюу 50 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	421.69	68.06	(353.63)
Бараа материал	36,024.42	77,725.77	41,701.35
Үндсэн хөрөнгө	621,216.94	908,888.00	287,671.06
<b>Нийт хөрөнгө</b>	<b>657,663.04</b>	<b>986,681.82</b>	<b>329,018.78</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	657,663.04	986,681.82	329,018.78
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>657,663.04</b>	<b>986,681.82</b>	<b>329,018.78</b>

Дээрх хүснэгтээс харахад авлага, бараа материал, үндсэн хөрөнгө дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

Бараа материал данс өмнөх оноос 41,701.3 мянган төгрөгөөр өссөн нь хандиваар 2,701.4 мянган төгрөгийн аж ахуйн материалыг орлогод авсан, тайлант онд 57,941.5 мянган төгрөгийн худалдан авалт, 18,941.6 мянган төгрөгийн өмнөх он болон тайлант оны зарцуулалт зэрэгтэй холбоотой байна.

Харин үндсэн хөрөнгө данс 287,671.1 мянган төгрөгөөр өссөн нь 18,000.0 мянган төгрөгийн автотээврийн хэрэгслийн худалдан авалт, хандиваар ирсэн 341,157.3 мянган төгрөгийн хөрөнгийг орлогод авсан, тайлант оны элэгдлийн зардалд 71,484.9 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн зэрэгтэй холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо /ээдийн өмч/ 329,018.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой болно.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр, нийт зарлагыг 637,820.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 113,979.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, нийт 751,800.0 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүй байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 52,047.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх орон нутгийн гүйцэтгэх засаглал хөтөлбөрийн үндсэн болон баг хороо, мэдээлэл сурталчилгаа, орон нутгийн нөөц хөрөнгө зэрэг 6 үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэхээр 803,847.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 796,623.2 мянган төгрөгийн санхүүжилт олгогдож, гүйцэтгэл 728,172.1 мянган төгрөг буюу 90.6 хувьтай бөгөөд үйл ажиллагааны орлого 68,451.1 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

Д/д	Код	Хөтөлбөр, арга хэмжээний нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	508,713.8	486,383.1	22,330.7	95.6
2	80106	Баг хорооны үйл ажиллагааны зардал	159,245.5	131,239.3	28,006.2	82.4
3	80205	Мэдээлэл сурталчилгааны зардал	4,924.2	1,200.0	3,724.2	0.0
4	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	59,864.5	59,864.4	-	0.0
5	81102	Орон нутгийн нөөц хөрөнгө	69,654.4	48,040.3	21,614.1	69.0
6	81701	Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх	1,445.0	1,445.0	-	100.0
		<b>Дүн</b>	<b>803,847.4</b>	<b>728,172.1</b>	<b>75,675.3</b>	<b>90.6</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтээр нийт 417,953.6 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлэх эс үүсвэр бүрдсэн бөгөөд 244,608.7 мянган төгрөгийг бараа үйлчилгээний зардалд зарцуулж, 173,344.9 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээ, төсөл хөтөлбөр гараагүй байна.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

/мянган төгрөг/

№	Тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо, хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөвт өртөг	Тухайн онд санхүүжих төсөвт өртөг	Шалгаруулалтын арга
1	Төрийн байгууллагуудын компьютер, тоног төхөөрөмжийг шинэчлэх	198,600.0	39,800.0	Нээлттэй тендер шалгаруулалтын арга
2	Сүмын булаг, Хар үзүүрийн тариалангийн талбайд ЦДАШ татах	200,000.0	0	Нээлттэй тендер шалгаруулалтын арга

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Цэцэн-Уул сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор нягтлан бодох бүртгэл, төсвийн гүйцэтгэл, сангийн сайдын тушаал, журамтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Баасанжаргал гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ц.Оюунсүвд аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Цэцэн-Уул сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 3/31 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг санхүүгийн тайлангийн суурь үзүүлэлтийн нийт орлого 420,543.9 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 8,410.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангаар материаллаг байдлыг сонгосон тул, гүйцэтгэх үе шатанд материаллаг байдлыг 2024 оны жилийн эцсийн тайлангийн нийт орлогын 1,282,735.3 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 25,654.7 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой төсвийг хэмнэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй ч батлагдсан төсвийн хүрээнд зарлага гарган ажилласан байна.

Энэ хуулийн хүрээнд цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 51,990.1 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 847.6 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 1,205.5 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 21,614.1 мянган төгрөгөөр тус тус хэмнэлт бий болгожээ.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ([shilendans.gov.mn](http://shilendans.gov.mn)) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим санд оруулсан байдлыг шалгахад дараа жилийн төсвийн /зорилтот түвшин/ төслийг хугацаа хоцроож мэдээлсэн, Санхүүгийн тайланг /хагас жил тутамд/ мэдээлээгүй, 15,367.9 мянган төгрөгийн аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан болон тухайн жилийн төсөвт /зорилтот түвшинд/ орсон нэмэлт, өөрчлөлт мөн нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл зэргийг мэдээлээгүй байна. Бусад үзүүлэлтээр мэдээлсэн байдлын хэрэгжилт 92.7%, хугацаа хоцролтын хэрэгжилт 98.7 хувьтай байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Цэцэн-Уул сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хийхэд зөрчил илрээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 47,831.4 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, 2 заалт бүхий зөвлөмж өгсөн байна. Албан шаардлагын хэрэгжилт 100 хувьтай байна. 1 заалт зөвлөмжийг хэрэгжүүлээгүй бөгөөд албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	3	47,831.4	3	47,831.4	100
Зөвлөмж	2	15,367.9	1	0	25
<b>Нийт дүн</b>	<b>5</b>	<b>63,199.3</b>	<b>4</b>	<b>47,831.4</b>	<b>31.25</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татсан асуудал гараагүй болно.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 94,823.5 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 94,823.5 мянган төгрөгийн алдааг залруулсан.

#### **Залруулсан алдаа:**

Аудитын явцад 18,800.0 мянган төгрөгийн нөөцийн өвсийг бараа материал дансаар дамжуулаагүй, шууд зардлаар тайлагнасан, 39,858.5 мянган төгрөгийн сумын төвийн гэрэлтүүлгийг данс бүртгэлд тусгаагүй, 18,000.0 мянган төгрөгийн худалдан авсан автомашиныг үндсэн хөрөнгийн тодруулга тайланд тусгаж, хөрөнгийн зардлаар тайлагнаагүй, 18,165.0 мянган төгрөгөөр цалингийн зардлыг зөрүүтэй илэрхийлсэн зэрэг алдааг залруулсан байна. Энэ нь УСНББОУС-1, АДБОУС 200, 2000, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4, 7.1.3.5 дахь заалтууд, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д "нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурь" гэж мөнгө хүлээн авсан, эсхүл төлсөн эсэхээс хамаарахгүйгээр орлогыг олсон үед, зардлыг гарсан үед нь хүлээн зөвшөөрч бүртгэх аргыг", 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 15 дугаар зүйлийн 15.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой

тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна”, 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна”, 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв байх, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитаар нийт 18,000.0 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 18,000.0 мянган төгрөгийн 2 заалт бүхий албан шаардлага өгсөн байна.

### **5.1 Төлбөрийн акт**

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчил илрээгүй байна.

### **5.2 Албан шаардлага**

Өмнөх онд газрыг үнэлж, данс бүртгэлд бүртгэх зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, мөн эрх бүхий байгууллагын шийдвэргүй Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 18,000.0 мянган төгрөгийн автомашин худалдан авч зориулалт бус зардал гаргасан нь өмнөх оны зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлээгүй байна.

### **5.3 Зөвлөмж**

Аудитаар зөвлөмж өгөхөөр алдаа, зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Заглуулсан		Заглуулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Нөөцийн өвсийг бараа материал дансаар дамжуулаагүй, шууд зардлаар тайлагнасан	1	18,800.0			1	18,800.0	1	18,800.0				
Сумын төвийн гэрэлтүүлгийг данс бүртгэлд тусгаагүй	1	39,858.5	1	39,858.5			1	39,858.5				
Худалдан авсан автомашиныг үндсэн хөрөнгийн тодруулга тайланд тусгаагүй	1	18,000.0	1	18,000.0			1	18,000.0				
Цалингийн зардлыг зөрүүтэй илэрхийлсэн	1	18,165.0			1	18,165.0	1	18,165.0				
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>94,823.5</b>	<b>3</b>	<b>57,858.5</b>	<b>2</b>	<b>36,965.0</b>	<b>5</b>	<b>94,823.5</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль хяналтын байгууллагад шийлжүүлсэн	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Өмнөх онд газрыг үнэлж, данс бүртгэлд бүртгэх зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй	2	-			1	-			1	1		
эрх бүхий байгууллагын шийдвэргүй Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 18,000.0 мянган төгрөгийн автомашин худалдан авч зориулалт бус зардал гаргасан	1	18,000.00			1	18,000.0						
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>18,000,000.0</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>18,000.0</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>0</b>

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
<b>Нийт дүн</b>								

### БАТАЛГААЖУУЛАХ ХЭСЭГ:

#### АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2025.02.25

АУДИТЫН МЕНЕЖЕР



Х.БОЛДБААТАР

2025.02.25

#### БЭЛТГЭСЭН:

АУДИТОР



Г.БААСАНЖАРГАЛ

2025.02.25